



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

90/1 оны 10 сарын 08 өдөр

Дугаар A/370

Мандалговь

Г Уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмал  
тээвэрлэх авто замд хяналт хийх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрч буй улсын болон орон нутгийн чанартай замаар уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмал тээвэрлэх аж ахуйн нэгжүүдэд хяналтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Анхбаяр	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Ш.Төрбат	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга)
	Б.Мөнхбат	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Н.Гантулга	(Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга)
	Ц.Хүрэлбаатар	(Аймгийн Автотээврийн төвийн дарга)
	Б.Энхмандал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	П.Очирбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзүл	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмалын тээвэрлэлт хийх улсын болон орон нутгийн чанартай авто замын маршрутаар тээвэрлэлт хийж буй аж ахуйн нэгжүүдэд 14 хоногийн хугацаатай удирдамжийн дагуу хяналт тавин, ажлын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



481-10176